



МОНГОЛ УЛС
ӨМНӨГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2020 оны 01 сарын 07 өдөр

Дугаар A/14

Даланзадгад

Ерөнхий боловсролын сургуулийн сурагчдын амралтыг сунгаж, сургуулийн өмнөх боловсролын байгууллагуудын үйл ажиллагаа, олон нийтийн арга хэмжээг түр хугацаагаар хязгаарлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2 дахь хэсэг, 29.1.5-ын “в” дэх заалт, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.1, Эрүүл мэндийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.4 дэх заалт, Эрүүл мэндийн сайдын 2014 оны “Томуу, томуу төст өвчний харуулдан тандалтын тогтолцоог өргөжүүлэх тухай” 358 дугаар тушаал, Эрүүл мэндийн сайдын 2018 оны “Томуугийн цар тахлын бэлэн байдал, хариу арга хэмжээний удирдамж батлах тухай” А/438 дугаар тушаал, 2020 оны 01 дүгээр сарын 07-ны өдрийн аймгийн Онцгой комиссын хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн хэмжээнд Томуу, томуу төст өвчний тархалт нэмэгдэж, 2020 оны 01 дүгээр сарын 07-ны өдрийн статистик мэдээгээр амбулаторийн үзлэгийн 20 хувийг эзэлж байгаа тул өвчний тархалтыг бууруулах, халдвартлах эрсдэлийг багасгах зорилгоор Ерөнхий боловсролын сургуулийн сурагчдын амралтыг 7 хоногоор буюу 2020 оны 01 дүгээр сарын 13-ны өдрөөс эхлэн 2020 оны 01 дүгээр сарын 19-ны өдрийг дуустал сунгасугай.

2. Олон нийтийг хамарсан сургалт, зөвлөгөөн, өдөрлөг, тэмцээн, уралдаан, секц дугуйлан зэрэг олон нийтийн арга хэмжээ, үзвэр үйлчилгээний газрын үйл ажиллагааг 2020 оны 01 дүгээр сарын 13-ны өдрөөс эхлэн 2020 оны 01 дүгээр сарын 19-ны өдрийг дуустал түр хугацаагаар хязгаарлаж, сургуулийн өмнөх боловсролын байгууллагуудын үйл ажиллагааг дээрх хугацаанд түр хугацаагаар зогсоосугай.

3. Томуу, томуу төст өвчний дэгдэлтийн үед бэлэн байдлыг хангаж ард иргэд, албан байгууллага, хамт олон, ажилчиддаа томуу, томуу төст өвчнөөс урьдчилан

2.

сэргийлэх мэдээлэл сургалт сурталчилгаа, зөвлөгөө, зөвлөмжөөр хангаж ажиллахыг төрийн болон төрийн бус байгууллагын дарга эрхлэгч наарт, нэгдсэн мэдээлэл, удирдлага арга зүйгээр хангаж ажиллахыг Эрүүл мэндийн газар /Ц.Өнөржаргал/, Бүсийн оношилгоо эмчилгээний төв /Я.Болдбаатар/-д тус тус үүрэг болгосугай.

4.Дээрх хугацаанд үзвэр, үйлчилгээ, олон нийтийн арга хэмжээ зохион байгуулагдаж буй эсэх, томуугаас сэргийлэх зорилгоор маск зүүж иргэдэд үйлчилгээ үзүүлж буй эсэх, хүн амын дундах маскны хэрэглээнд хяналт тавьж, үүрэгжүүлж ажиллахыг Цагдаагийн газар /Г.Наранбаатар/, Мэргэжлийн хяналтын газар /Д.Мөнхтулга/, Улаан загалмайн хороо /Л.Энхжаргал/-д тус тус үүрэг болгосугай.

5.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж томуу, томуу төст өвчний тархалтын байдал, амбулаторийн үзлэгт эзлэх хувь хэмжээнд дүн шинжилгээ хийн 7 хоног бүр аймгийн Засаг даргад тайлagnаж ажиллахыг Нийгмийн бодлогын хэлтэс /Ү.Энхцацрал/-т үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА

Н.НАРАНБААТАР

